



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ”

**Аудит хийсэн
үндэслэл,
бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.

“БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА”

**Аудитын
тайланг
хүргүүлсэн:**

Аймаг, сумдын сонгуулийн хороодод тус тус хүргүүлсэн.

Дархан-уул аймаг
2024 оны 08 дугаар сар

**Аудитын
зорилго,
зорилтууд**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан ҮАГ, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;*
- *УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон*

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудыг хамруулан гүйцэтгэлээ.

**Аудит хийхэд
гарсан
хүндрэл
бэрхшээл**

Аудитад хүндрэл бэрхшээл гараагүй болно.

БҮЛЭГ 1.1. СЕХ-НООС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ӨГСӨН ЗААВАР ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1.1 Сонгууль зохион байгуулах зардлын төсвийг холбогдох тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөжээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу Дархан-Уул аймагт Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлын төсвийг тооцохдоо сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо зэрэг мэдээллийг үндэслэн 437.4 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан нь 2020 оны төсөвтэй харьцуулахад 1.8 дахин нэмэгдсэн байна.

Дээрх хуулийн нэмэлт өөрчлөлтөөр /2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн/ аймаг, сумын сонгуулийн хороо, хэсгийн хорооны тоо, гишүүд, МТБ, даамлын тоо нэмэгдсэнээр урамшуулал, хоол, унааны болон бусад зардал өссөн нь нөлөөлжээ.

Харин бичиг хэрэг, маягт хэвлэх, шуудан холбооны зардлыг тогтмол байхаар тооцож ирүүлсэн байна.

1.1.2 Сонгуулийн хороодод зардлыг хуваарилахдаа СЕХ-ноос өгсөн чиглэлийг баримталсан байна.


Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулж, СЕХ-ны Тамгын газрын даргын 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/45 дугаар тушаалаар аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийг баталж, зарцуулалтын тайлбар болон анхаарах асуудлуудаар тодорхой чиглэлийг өгчээ.

СЕХ-ноос аймгийн сонгуулийн зардлын төсвийг эдийн засгийн ангилал бүрээр тооцож, 5 удаагийн санхүүжилтээр нийт 437.4 сая төгрөгийг бүрэн олгожээ.

Ингэхдээ 45 хэсгийн хороонд нийт 502 төрийн албан хаагч ажиллахаар тооцож тэдгээрийн цалин, урамшуулал, хоолны зардал, хэсгийн хороодын унаа, томилолт, бичиг хэрэг, шуудан холбоо, сургалт гэх мэт зардлыг тооцож, зарцуулах заавар, чиглэлийг аймгийн сонгуулийн хороонд ирүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хороо нийт батлагдсан төсвийн 11.0 хувь буюу 49.5 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хороонд, 89.0 хувь буюу 387.8 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороонд тус тус хуваарилжээ. Үүнийг дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл №1



Аймгийн сонгуулийн хорооноос Дархан сумын сонгуулийн хороонд 290.8 сая төгрөг, Орхон суманд 23.8 сая төгрөг, Хонгор суманд 33.3 сая төгрөг, Шарын гол суманд 39.9 сая, нийт 387.8 сая төгрөгийн төсвийг хуваарилахдаа СЕХ-ноос

өгсөн төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг баримталж ажилласан эсэхийг аудитаар 10 төрлийн зардлын хувьд давтан тооцоолоход алдаа зөрчил илрээгүй болно.

1.1.3 Аймгийн Цагдаагийн газар болон Улсын бүртгэлийн хэлтсийн сонгууль зохион байгуулах зардлын төсвийг төвлөрүүлэн захирагчаас хуваарилан олгожээ.

Аймгийн Цагдаагийн газар болон Улсын бүртгэлийн хэлтсээс сонгуулийн зардлын төсвийн төслийн тооцооллыг дээд шатны байгууллага гаргуулан аваагүй байна. Харин СЕХ-нд ЦЕГ-аас саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хамгаалах, хүргүүлэх үеийн хамгаалалт, санал авах байр болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах, дүн дамжуулах үеийн хамгаалалтын шатахуун, шуудан холбоо, албан хаагчийн хоолны зардлыг тооцоолж, батлуулснаар аймгийн Цагдаагийн газарт 28.9 сая төгрөг хуваарилсан.

Мөн УБЕГ-аас СЕХ-нд сонгогчийн бүртгэлийн тулган шалгах, бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах болон бусад зардлын тооцоо, судалгааг хүргүүлснээс Улсын бүртгэлийн хэлтэст 50.9 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна.

1.2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ.

1.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 2.6 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд 437.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 434.8 сая төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 2.6 сая төгрөгийг СЕХ-ны 100900022001 тоот дансанд төвлөрүүлжээ.

Хүснэгт №3

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн харьцуулсан судалгаа

(мянган.төгрөг)

№	Сонгуулийн хорооны нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Дархан-Уул аймаг	49,561.0	47,047.2	2,513.8
2	Дархан сум	290,787.0	290,732.0	55.0
3	Хонгор сум	33,333.0	33,311.0	22.0
4	Орхон сум	23,829.0	23,829.0	-
5	Шарын гол сум	39,852.0	39,841.0	11.0
Нийт дүн		437,362.0	434,760.2	2,601.8

Энэ нь аймаг, сумдын сонгуулийн хорооны гишүүдийн урамшууллаас групп болон тэтгэвэрт гарсан 8 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүү 0.1 сая төгрөг, болзошгүй зардлаас 0.3 сая төгрөг, томилолтын зардлаас аймгийн төвийн суманд ажилласан томилолтыг олгоогүй 0.6 сая төгрөг, шуурхай баг буюу МТБ-ийн унааны зардлаас аймгийн төвөөс сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороод хүртэлх зайг бодит гүйцэтгэлээр тооцож олгосноор 1.6 сая төгрөг тус тус хэмнэсэн нь нөлөөлжээ.

Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд төсөв нийт дүнгээр болон зардлын нэр төрлөөр хэтрээгүй, зүйл анги хооронд шилжүүлэн зарцуулаагүй байна. Аудитаар сонгуулийн хороодын төсвийн зарцуулалтыг дансны хуулга, холбогдох анхан шатны баримтуудтай тулган шалгахад алдаа зөрчил илрээгүй.

ЦЕГ-ын санхүү, ар талын албаны даргын 2024 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 16/1911 тоот албан бичгийн дагуу Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтад ажиллах хүн, хүчний тооцооллыг хүргүүлсний дагуу Дархан-Уул аймгийн Цагдаагийн газарт 28.9 сая төгрөгийг хуваарилсныг 100 хувь зарцуулсан байна.

Мөн УБЕГ-ын даргын 2024 оны 02 сарын 15-ны А/24, А/104 А/367 тоот тушаалаар 50.9 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, 100 хувь зарцуулжээ.

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар болон Улсын бүртгэлийн хэлтсийн сонгуулийн зардлын зарцуулалтыг дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

1.2.2 Аймаг, сумдын сонгуулийн хороо батлагдсан төсвийн дагуу зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнажээ.

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах,

хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралтын дагуу сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг хянан хүлээн авч, аймгийн сонгуулийн хороо нэгтгэн тайлагнасан байна.

Сонгуулийн нийт зардлын гүйцэтгэлийн 76.4 хувь нь сонгуулийн хороодын гишүүдийн урамшуулал, 8.2 хувь нь унааны зардал, 3.3 хувь нь томилолтын зардал, 3.1 хувь нь санал авах байр, тохижуулах зардал, 3.5 хувь нь шуудан холбоо, бичиг хэргийн зардал, 1.8 хувь нь сургалт, сурталчилгааны зардал, бусад зардал 3.7 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг дансны хуулга, анхан шатны баримттай тулган шалгахад ажил, гүйлгээ тус бүрийн баримтыг хангалттай бүрдүүлж, зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнажээ.

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар болон Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн зардлын тайланг хугацаанд нь дээд шатны байгууллагад тайлагнасан байна.

1.2.3 Аймгийн сонгуулийн хороо төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 онд гүйцэтгэсэн “УИХ-ын 2020 оны сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн “СЕХ-оос өгсөн зөвлөмж, чиглэлийг баримталж, хуваарилсан төсвийг зүйл анги хооронд шилжүүлэхгүй байх” зөвлөмжийг аймгийн сонгуулийн хороо хэрэгжүүлж ажиллажээ.

Ингэхдээ аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хороодын санхүүжилтийг олгох бүрд зардлын нэр төрөл бүрээр төсвийн хуваарилалтыг хүргүүлж, зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.

Түүнчлэн “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10¹-т заасны дагуу хяналтыг хэрэгжүүлснээр шуурхай баг буюу МТБ-ийн унааны зардлыг аймгийн төвөөс сумдын хэсгийн хороодын зайг бодитой тооцон, олгож ажиллажээ.

Мөн аймгийн Цагдаагийн газрын захиргаа удирдлагын тасгаас УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтад ажиллах албан хаагчдын хуваарийг батлуулан, зардлыг санхүүжүүлэхдээ тухай бүр хяналт тавьж ажилласан байна.

¹ Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн сонгуулийн хороо улсын төсвөөс олгосон санхүүжилтийг СЕХ-ноос өгсөн заавар, чиглэлийн дагуу тооцож, сумдын сонгуулийн хороодод хуваарилсан байна.
2. Сонгуулийн зардлыг батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулжээ.
3. Аймаг, сумдын сонгуулийн хороо нь “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу зардлын тайланг үнэн зөв, бодитой тайлагнажээ.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР